

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“СТОК БЛАСТ”ХХК ЗАХИРАЛ:

Б.МӨНГӨНЦООЖ

“СТОК БЛАСТ” ХХК-ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5631262

ХЯНАСАН:
ХБӨБЗГ МЭРГЭЖИЛТЭН:

П. ШИНЭЦЭЦЭГ

СТОК БЛАСТ ХХК-ИЙН
ХАБЭА,БО МЕНЕЖЕР :

Б.ЭРДЭНЭБИЛЭГ

Гарчиг

1. Төслийн товч танилцуулга.....	3
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	11
байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	11
5. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.	12
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	14
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
11. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	19
12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө..	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Булангийн цэгийн солбилцол	5
Хүснэгт 2 Тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт	5
Хүснэгт 3 Төслөөс үүсч болзогшгүй сөрөг нөлөөлөл	9
Хүснэгт 4 БОМТ-ний зардлын задаргаа	11
Хүснэгт 5 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал	11
Хүснэгт 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 7 Орчны тохижилт, “Тэрбум мод” хөтөлбөрийн төлөвлөгөө	14
Хүснэгт 8 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
Хүснэгт 11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
Хүснэгт 13 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Бодисын агуулах	3
Зураг 2 Төслийн байршил	4

ТОВЧИЛСОН ҮГ

БОАЖСайд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
БОЯБ	Биологийн олон янз байдал
ОХШХ	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч: “Сток бласт”ХХК

Регистрийн дугаар: 5631262

Төслийн нэр: “Тэсрэх бодисын үйдвэр, агуулах”

“Сток бласт” ХХК нь анх 2012 оноос гадаад худалдаа болон барилгын засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан ба 2020 онд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн үйлдвэрлэлийн зориулалттай, тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл аван дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. “Сток бласт” ХХК-ийн үйлдвэр агуулах нь Тавантолгой ордын дэргэд байрлаж байгаагаараа онцлог юм. Төсөл хэрэгжүүлэгч нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Ухаа худаг болон Баруун Наран нүүрсний ил уурхайд тэсэлгээний ажил үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эхний ээлжид уг хэрэглэгчийн энгийн тэсрэх бодисын хэрэглээг хангахаар төлөвлөн ажиллаж байна.


Сток бласт ХХК-ийн хөдөлгөөнт холин цэнэглэх машин нь БНХАУ-ын уул уурхай салбарт түгээмэл хэрэглэгддэг Sinotruck howo 380 маркийн өөр дээрээ 15 тн аммиакийн шүү ачааллах бункер, 2тн дизель түлш ачих савтай бүхий үндсэн холигч болон өргөх, цэнэглэгч шурган дамжуулагч, дозлогч насос, тохируулгын функц зэргээс бүрдсэн иж бүрэн төхөөрөмж бөгөөд аммиакийн шүү, дизель түлшийг тус тусад нь ачин тээвэрлэж тэсэлгээний цооногт цэнэглэх явцдаа түүхий эдүүдийг орц нормын дагуу холих замаар энгийн тэсрэх бодис үйлдвэрлэдэг аюулгүй байдлыг бүрэн хангасан, хялбар технологи бүхий хөдөлгөөнт үйлдвэр юм.




Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төсөл

Сток бласт ХХК-ийн 5 га талбайд:

- Хуурай химийн бодисын агуулахын барилга
- Нойтон химийн бодисын агуулахын барилга
- Харуул хамгаалалтын байр



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 2 Төслийн байршил

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ” ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 1 Булангийн цэгийн солбилцол

Булангийн цэгийн №	Х	Ү
1	520785.53	4834141.56
2	520926.05	4834349.13
3	521096.67	4834244.33
	520955.98	4834037.62

Төслийн техник технологи, эдийн засаг, хүчин чадал

“Сток бласт” ХХК-ийн энгийн найрлагат тэсрэх бодисын хөдөлгөөнт үйлдвэрийн бүрэн хүчин чадал нь 1 ээлжээр, ээлжинд 2 удаагийн цэнэглэлтэйгээр жилийн турш тасралтгүй ажиллахад 10500 тн/жил байх боломжтой юм. Харин энэхүү төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил үйлчилгээ үзүүлж буй төслийн одоогийн бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөх юм. Үйлдвэрийн ажиллагааг хоногт 1 ээлжээр буюу өдөрт 2 удаагийн цэнэглэлтэйгээр ажиллуулахаар төлөвлөж байна. Түүхий эд болон тэсэлгээний хэрэгслийн агуулах байрлаж буй талбайгаас автозамаар 9.5 км зайд байрлаж буй Баруун нарангийн нүүрсний уурхай болон зүүн тийш 20 км зайд орших Ухаа худгийн нүүрсний уурхайд шаардлагатай энгийн найрлагат тэсрэх бодисын бодит хэрэглээнд тулгуурлан тооцоолсон. Төсөл хэрэгжүүлэгч нь Баруун нарангийн уурхайд жилд 4200 орчим тн энгийн тэсрэх бодис хэрэглэх бол Ухаа худгийн уурхайд 1500-1800 тн энгийн найрлагад тэсрэх бодис үйлдвэрлэн нийлүүлнэ.

Хүснэгт 2 Тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт

Ашиглалтын жил	Аммиакын шүү, тн	Дизель түлш, тн	Анфо, тн
1-р жил	564	36	600
2-р жил	5,640	360	6,000
3-р жил	5,640	360	6,000
4-р жил	5,640	360	6,000
5-р жил	5,640	360	6,000
6-р жил	5,640	360	6,000
7-р жил	5,640	360	6,000
8-р жил	5,640	360	6,000
9-р жил	5,640	360	6,000
10-р жил	5,640	360	6,000
Дүн:	51,324	3,276	54,600

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Сток бласт” ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагат тэсрэх бодисын хөдөлгөөнт үйлдвэр, агуулах байгуулагдах талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт харьяалагдах бөгөөд Цогтцэций сумын төвөөс баруун урагшаа 25 км, Улаанбаатар хотоос баруун урагшаа 540 км, Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордоос баруун тийш 16 км, Баруун Нарангийн уурхайгаас зүүн хойш 8 км зайд тус тус байрлана. Үйлдвэрлэлийн зориулалттай Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах агуулах байгуулахаар төлөвлөж буй газрыг Өмнөговь аймгийн Ханхонгор сумын засаг даргын 2019 оны 07-р сарын 31-ны өдрийн А/82 тоот шийдвэрээр 5 га газрыг “Уурхайн барилга байгууламж, тэсэлгээний агуулах”-ын зориулалтаар, 60 жилийн хугацаатай “Сток бласт” ХХК-д олгосон байна.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Төслийн талбай нь Монгол орны өмнөд хэсгийг эзэлсэн говь-талын бэсрэг хэлхээ уулс, тэдгээрийн хооронд хотос тал хөндийнүүд зонхилсон нутагт оршино. Тухайн бүс нутгийн хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1791 м өргөгдсөн Цэций уул, Их шанхын нурууны оргил Өгөөмөр уул 1789 м бөгөөд тэдгээрийн хэлхээ бэсрэг уулууд баруун урдаас зүүн хойш чиглэн сунаж тогтсон байх бөгөөд өндөршлийн зөрүү 100м-ээс үл давах ажээ. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газарзүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр нь Э. М. Мурзаев цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтаан үзжээ. Хан-Уул, Буурын ар, Хацарын хэц зэрэг газраар тоосгоны сайн чанарын улаан шавар, шохойн чулуу, хужир, давс зэрэг ашигт малтмал, Давст, Хулст, Аяган, Шанаган зэрэг газарт хүнсний давс, шороон хужиртай, түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга, сайр чулууны арвин нөөцтэй байдаг. Тус суманд Говь-Гурвансайхан уулын, Ёлын хөндий, Хан-Уулын тухай, Хэрмэн замын, Дөрвөлж хар бүйлсний, Цагаан-Хайрхан уулын зэрэг домогт газрууд байдаг байна. Таван Толгойн бүс нутаг нь ерөнхийдөө Улаан нуурын хотгорт байрлах бөгөөд хотгорын хойд талаар Наранцанхийн хагарал, өмнөд хэсгээр Хайрханы хагарлаар зааглагддаг. Энэхүү бүс нутагт газар хөдлөлийн талаар урьд өмнө тусгайлсан судалгаа хийж байгаагүй боловч Монгол орны чичирхийлэл, тектоникийн мужлалаар газар хөдлөлтийн 7 баллын бүсэд оршдог бөгөөд давтамж нь 1000 жилд 2 удаа байх магадлалтай байна.

Уур амьсгал

Төслийн талбай нь Ханхонгор сум болон Цогтцэций сумын зааг хэсэгт орших бөгөөд тухайн бүс нутаг нь эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарах бөгөөд төслийн талбай орчимд 11 дүгээр сарын дундаас хүйтний эрч чангарч, 3-р сарын эхээр дулаарч эхэлдэг байна. Өвлийн улирлын саруудад цаг агаар гол төлөв цэлмэг тогтуун байдаг ба хамгийн хүйтэн үе буюу 1 дүгээр сарын дундаж агаарын температур -15 хэм, үнэмлэхүй хамгийн бага температур -38°C-д хүрч хүйтэрдэг ба хур тунадасны унах хэмжээ 9.6 мм байдаг байна. Салхи зонхилон баруун, баруун хойноос үлээх ба зарим тохиолдолд говьд ховор тохиолдох угалз буюу хүчтэй шороон шуурга болдог байна. Тус нутгаар хаврын улиралд агаарын температурын хэлбэлзэл ихсэж, салхины хурдны их утга ажиглагдан, чийг багасаж агаар хуурайшдаг бөгөөд цаг агаар огцом өөрчлөгдөж тогтворгүй байдаг байна. Энэ үед салхины дундаж хурд 5.0-5.2 м/с, хамгийн их хурд нь 40 м/с хүрдэг байна. Үйлдвэрийн орчмын нутаг дэвсгэр нь чийг багатай, хуурай дулаавтар мужид багтдаг, агаар ба хөрсний температурын хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага учраас нэлээд хуурайшилттай, салхи шуурга ихтэй, улирал нь огцом солигддог онцлогтой. Эмulsionийн үл тэсрэх хольцын үйлдвэр орчмын уур амьсгал нь эх газрын эрс тэс, нэн хуурай, дулаан хээр говийн уур амьсгалын ангилалд багтана. Говийн уур амьсгалын эрс тэс шинж нь хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижил, зундаа халуун-хуурай, өвөл харьцангуй дулаавтар, хавар салхи шуургатай, хаврын эхэнд жаварлаг, хаврын сүүл рүү нэн хуурайшил ихтэй байдгаас хамаарна. Жилийн дулаан үе нь 29/III-28/V хүртэл 219 хоног үргэлжилдэг нь манай орны хойд хэсгээс 30-40 хоногоор илүү байна. Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлд эерэг нөлөө үзүүлдэг. Дулаан улирлыг 3 үе болгон хувааж үзэхэд эхэн 33 хоног, дунд үе 149 хоног, сүүл үе 31 хоног,

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

нийт 213 хоног болж байна.

Жилийн хүйтэн үе нь 28/X-29/III-ний хооронд 152 хоног үргэлжилж байгаа нь өвөл харьцангуй богино болдгийг харуулна. Хүйтэн улирлыг 3 үе болгон хуваавал эхэн үе 35 хоног, харин дунд үе 81 хоног, сүүл үе 36 хоног буюу нийт 152 хоног болох ба 81 хоногт нь дүн өвөл болдог байна. Цогтцэций сум орчмын нутагт хур тунадас бага ордог. Олон жилийн дундаж нийлбэр хэмжээгээр 125 мм тунадас унасны 97% нь дулааны улиралд хур борооны төрлөөр, үлдсэн 3% нь цас хэлбэртэй хүйтэн улиралд ордог. Салхи шуурга нь говь, тал нутагт их хүчтэй, ноёлох чиглэл нь тод илэрдэг бөгөөд орчны бохирдол, тоос шороо зөөгддөг онцлогтой. Салхины чиглэл нь өвөл баруун өмнөөс хойт зовхисын чиглэлд ноёлж, Улаан нуурын хотгор, хөндийн дагуу баруун өмнөөс (18.3%), баруун баруун хойноос (12.2-2.7%) ноёлно. Хавар IV сард баруун өмнөөс баруун хойд зовхисын салхи (15-27.5%) ноёлно. Зун VII сард зүүн өмнөөс (20%), баруун хойноос (21%), хойд болон баруун өмнөдөөс (8-17%), намар X сард баруун өмнөөс баруун хойд (16-27%), зүүн өмнөөс (11.4%) тус тус ноёлох бөгөөд хотгор, гүдгэрийн хэв шинжтэй байна. Салхигүй байх давтагдал энэ бүс нутагт их биш, хавар 16%, бусад сард 2540%/ байгаа нь салхирхаг нутгийн шинж юм.

Геологийн тогтоц ба ландшафт

Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэр нь геологийн тогтцын хувьд карбоны вулканоген-тунамал хурдас, хожуу карбон-доод пермийн вулканоген чулуулаг, харин төв хэсэгт нь дээд пермийн нүүрс агуулагч хурдас зонхилон тархсан ба хэсэг хэсэг жижиг талбайд юра, цэрд, палеоген, неогены настай тунамал, туфоген-тунамал, терриген хурдсууд тааралдана.

Монгол орны ландшафтын мужлалаар төслийн талбай нь талын ландшафтын бага хэрчигдэлтэй эвдрэл элэгдлийн төрөлд багтах бөгөөд цөлжүү хээрийн ба заримдаг цөлийн хэв шинжийн заримдаг цөлийн дэд хэв шинжид хамаарагдана. Эвдрэл-элэгдлийн нам толгод, гүвээ нь талбайн баруун хэсэг болох Нарийн Хар уул, Их Тэмээ, Бага Тэмээний хярыг хамарна. Энэ төрлийн ландшафт голдуу бялхмал, тунамал-бялхмал чулуулгаас тогтоно. Толгод гүвээ нь янз бүрийн хэлбэртэй, жижиг судаг, сайруудаар хэрчигдсэн, 10°-15°, заримдаа 20°-30° хүртэл налуутай бөгөөд хавтгайдуу оройтой байна. Түр зуурын урсгал усны нөлөөгөөр модны мөчир хэлбэртэй хуурай сайр, гуу жалгын сүлжээ үүссэн бөгөөд эдгээр сайруудын адгаар зөөгдлийн конус, уруйн бүдүүн хэмхдэст хурдаснаас тогтсон жижиг довцгууд ажиглагдана.

Гадаргын болон газрын доорх ус

Газарзүйн байрлал, гадаргын онцлог. Судалгааны талбайн эргэн тойрон нь далайн түвшнээс дээш дунджаар 1000-1200 м-т өргөгдсөн говь тал хээр хосолсон нутаг юм.

Ус зүйн муж: Төв Азийн гадагш урсацгүй ай савын түр урсгал бүхий гол горхины мужид

Сав газар: Галба-Өөш-Долоодын говь,

Энэ бүс нутаг гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага байна. Гуу жалга, сайрууд цас их унасан жилд хаврын улиралд шар усны үертэй, харин зуны улиралд хур борооны усаар тэжээгдэн үерлэнэ. Судалгааны талбайд бүртгэгдсэн гадаргын уст цэг байхгүй. Амрах байр болон үйлдвэрийн талбай ойролцоо сайр байхгүй харин энэ хоёрыг холбосон сайжруулсан шороон замыг хөндлөн дайрч байгаа нэг судаг байна.

2024 оны 10 сарын 9-нд судалгааны талбайн ойролцоо байдаг “Сток бласт” ХХК-ны унд, ахуйдаа хэрэглэдэг худаг дээр очиж дээж авсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ” ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гидрогеологийн муж: Улирлын хомс тэжээлтэй муж

Дорноговийн дэд мужид

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натри, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь ундны усны стандарт MNS900:2010-ын шаардлага хангаж байна.

Ургамлан нөмрөг

Ургамлын бүлгэмийн хувьд монгол өвс (*Stipa gobica*), таана (*Allium polyrrhizum*), бор бударгана (*Salsola passerina*), улаан бударгана (*Reamuria soongarica*), түнтгэр баглуур (*Anabasis brevifolia*), гялгар дэрс (*Achnatherum splendens*), шар бударгана (*Kalidium foliati*), сибирь хармаг (*Nitraria sibirica*), зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes soongarica*), хөмүүл (*Allium mongolicum*), төлөгчдүү бор таар (*Ajania nelillous*), орог тэсэг (*Eurato ceratoides*) зэрэг ургамлууд бүрдүүлж байна. Үүний дотроос монгол өвс-таанат бүлгэмдэл, монгол өвс-баглуурт бүлгэмдэл, монгол өвс-бор бударганат бүлгэмдэл, бор бударгана-улаан бударганат бүлгэмдэл, шар бударгана-улаан бударгана-бор бударганат бүлгэмдэл, дэрст бүлгэмдэл, сибирь хармагт бүлгэмдэл зонхилно.

Амьтны аймаг

Таван Толгойн орчмын нутагт гадаргын ус байхгүй, нутгийн ихэнх хэсэг хуурайсаг, харин бороо хур элбэгтэй жилүүдэд Улаан нуур мэтийн шал, хоолой дагаж задгайран ус тогтдог нь намар болон зун ус хайн орж ирэх хэвлээр явагч, хөхтөн болон шувуудын зүйлүүдэд нэн таатай нөхцөл бүрдүүлдэг. Шалын ус удаан хугацаагаар оршин байхын зэрэгцээ чийглэг орчин бүрэлдүүлж, богино хугацаанд өсч үрждэг сээр нуруугүй амьтад, тухайлбал шавьж (шумуул), хавч хэлбэртний (дафни, циклоп, шанаган хорхой г.м) биомассыг нэмэгдүүлдгээс усны ойролцоо байх буюу усанд татагддаг шувууд цуглах боломж бий болгоно. Цогтцэций сумын нутгийн Таван Толгой орчимд явуулсан судлаачдын мэдээллээс үзэхэд монгол бахаас (*Bufo raddei*) өөр хоёр нутагтан амьтан тархаагүй, 1 багийн 5 овогт багтах 10 зүйл хэвлээр явагч тохиолддог, нийт бүртгэгсэн 62 зүйл шувуунаас суурин амьдралтай 22 зүйл, нүүдлийн 40 зүйл шувуутай, 7 баг, 14 овогт хамрах 40 зүйл хөхтөн амьтан байх боломжтой байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлс

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших “Сток бласт” ХХК-ийн Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын талбайн ойр орчим түүх, соёлын дурсгалын ач холбогдолтой ямар нэгэн зүйлс байхгүй болно. Гэвч ордын үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдох аваас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шаардлагатай.

Төслийн талбайгаас 100км болон түүнээс их зайд орших тусгай хамгаалалттай газрууд:

- Загийн ус - Байгалийн нөөц газар
- Говь гурван сайхан - Байгалийн цогцолборт газар
- Сүйхэнт - Дурсгалт газар
- Эргэлийн зоо - Байгалийн нөөц газар
- Говийн бага Б - Дархан цаазат газар

Говийн бага А - Дархан цаазат газар

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 3 Төслөөс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Болзошгүй нөлөөлөл	Бүс нутгийн түвшинд	Аймгийн түвшинд	Сум буюу орон нутгийн түвшинд	Төслийн талбайн хэмжээнд	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	
	Агаарын чанарын өөрчлөлт	0	0	0	х	Агаар бохирдож болзошгүй
	Чимээ шуугиан	0	0	0	0	
	Гадаргын болон гүний усны нөөц, горим	0	0	0	0	
	Хөрсний чанар, геоморфологи	0	0	х	х	Хөрсөнд химийн бодис асгарсан тохиолдолд хөрс хүнд металаар бохирдоно
2	Усны ургамал, амьтан	0	0	0	0	Төслийн талбайд байгалийн ургамал, амьтан байхгүй
	Эх, газрын ургамал, амьтан	0	0	0	х	Ургамлын бүтэц өөрчлөгдөх
	Тусгай хамгаалалттай газар нутаг	0	0	0	0	
	Дархан цаазтай амьтан, ургамлын төрөл зүйл	0	0	0	0	
3	Аж үйлдвэр, зам тээвэр	0	0	0	х	Сайжруулсан шороон зам барьсан.
	Хөдөө аж ахуй	0	0	0	0	
	Орон нутгийн усны хангамж	0	0	0	х	Төслийн үйл ажиллагаанд ахуйн хэрэглээнээс өөр зориулалтаар ус хэрэглэхгүй
	Хаягдал усны менежмент	0	0	0	0	
	Хатуу хог хаягдлын менежмент	0	0	х	х	Химийн бодисын ашиглагдсан сав баглаа боодлыг орон нутгаас ирж, тээвэрлэж устгуулна.
	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	0	0	0	х	Хэрэглээ нэмэгдэх магадлалтай.
4	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ.
	Археологи, палеонтологи	0	0	0	0	
	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	0	0	0	0	

Жич: “Х”-сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай

“О”-нөлөө үзүүлэхгүй

“+”-эерэг нөлөө үзүүлэх тэмдгээр харуулав.

Хүснэгтээс харахад, агуулах төсөл нь том талбайг хамарсан үйлдвэрлэл бүтээн байгуулалтын төсөл биш учраас бүс нутаг, аймгийн түвшинд дам байдлаар агаарын чанар, эрчим хүч, нийгэм эдийн засагт нөлөөлж болзошгүй. Харин сум орон нутаг, талбайн хүрээнд шууд болон дам байдлаар агаарын чанар, орон нутгийн ус хангамж, эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент, нийгэм-эдийн засгийн байдал, нийгмийн эрүүл мэнд

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

аюулгүй байдал зэрэгт нөлөөлж болзошгүй нь харагдаж байна.

Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисуудыг хадгалахдаа аюулгүйн ажиллагааны дүрмийг баримтлаагүй улмаас химийн бодис ихээр алдагдсанаар агаарт дэгдэж хүний эрүүл мэндэд нөлөөлж болох ба бодис алдагдсан цаг тухайд саармагжуулах аргыг хэрэглэвээс нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна. Мөн хог хаягдлыг ил задгай зөвшөөрөгдсөн ангиллын дагуу бус устгаснаас нөлөөлөл үүсэж болзошгүй юм. Агаарын бохирдол нь хамрах хүрээ хязгаарлагдмал, бодис бүрийг зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу устгавал агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага болно.

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх. Химийн бодисын сав баглаа боодлыг хуулийн дагуу зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагаар зайлуулаагүйгээс хөрсөн бүрхэвч бохирдох, тээврийн хэрэгслийн түлш шатахууны шүүрэл, асгаралтаас хөрс бохирдох зэрэг нөлөөлөл үүсэх магадлалтай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь "Сток бласт"ХХК-ийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, БОАЖСайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт болон БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Хүснэгт 4 БОМТ-ний зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	5950
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	1050
3	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчид тайлагнах	-
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	7000

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө бөгөөд уг төлөвлөгөөнд нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн.

Хүснэгт 5 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	2200
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	2250
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1500
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	-
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал	5950

5. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
АГААРЫН ЧАНАР ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ									
1.	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	Агаарын чанарыг тогтмол хянах, хэмжих	Агуулах орчим	Хяналт шинжилгээний зардалд орно.				Төсөл хэрэгжих хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2025 - MNS 3384:82
2.		Ажлын байр, агуулах, барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах	Агуулах, төслийн барилга байгууламж	Үйл ажиллагааны зардалд орно.				Төсөл хэрэгжих хугацаанд	
3.	Авто машин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Нийт тээврийн хэрэгсэл		Дотоод төлөвлөлтөөр			Төсөл хэрэгжих хугацаанд	
УС, УСНЫ ЧАНАР ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ									
4.	Ундны усны чанар аюулгүй байдал	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон					Жилд нэг удаа	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
5.	ахуйн бохир ус алдагдаж, гадаргын болон газрын	Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулах	Үйл ажиллагааны зардалд орно.					Жилд нэг удаа	

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	доорх усны нөөцийг бохирдуулах								
УРГАМЛАН НӨМРӨГ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ									
6.	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1 удаа хийлгэх	Үйлдвэрийн талбайн болон орчны бүсэд	Тайлан	2200	1	2200	Жилд нэг удаа	Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална.
7.		Машин механизмыг зориулалтын зам талбайд тавьж, засвар үйлчилгээ хийж, угааж цэвэрлэж байх	Компанийн нийт тээврийн хэрэгсэл	Үйл ажиллагааны зардалд орно.				Төслийн хугацаанд	
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
8.	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулж, төлбөрөө төлөх	Үйл ажиллагааны зардалд орно.					-	
9.		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсөнд шинжилгээ хийлгэх	Хяналт шинжилгээний зардалд орно					Жилд нэг удаа	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019
10.	Тээврийн хэрэгсэлтэй холбоотой үүсэх бохирдол	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар арчилгаа хийх	Үйл ажиллгааны зардалд орно.					Төслийн хугацаанд	MNS 4597:2014 MNS 4596:2014
13.		Тоног төхөөрөмжийн тос солих газрын хөрсийг хамгаалах	Засвар хийх талбай	Үйл ажиллагааны зардалд орно.				Төлсийн хугацаанд	
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ				2200					

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн бүс нутаг нь салхины нөлөөлөл ихтэй, мөн нүүрсний олборлолтын үйл ажиллагаанаас цөлжилтийн үйл явц эрчимтэй явагдаж, тоосжилт ихээр үүсэх болсон байна. “Сток бласт” ХХК нь тэсрэх бодисын агуулахдаа “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 200ш модыг орон нутгаас заасан талбайд нэгдсэн журмаар тарихаар төлөвлөв.

Хүснэгт 7 Орчны тохижилт, “Тэрбум мод” хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	“Тэрбум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд		Ажилчдын байрлах хэсэг	ш	200	11,25	2250	9-р сард	Орон нутгаас нэгдсэн зохион байгуулалттай хийгдэх ажил
	Нийт						2250		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сток бласт” ХХК нь цаашид нэмж барилга байгууламж барих тохиолдолд газар шорооны ажлын үед газрын хөрсөн доороос мэдэгдээгүй үлдсэн соёлын биет өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т зааснаар “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллана.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төлөвлөгөөнд байгалийн аюул, гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгасан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн аюул, гамшгийн нөхцөл байдал үүсэх	Агуулахын талбайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Талбайн хэмжээнд	-	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Талбайн хэмжээнд	6-8 хүнд	-	ХАБИА-н зардалд тусгана	Улиралд 1 удаа	
		Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Талбай, амьдрах байр	-	-	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Усны тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД-30.01.03
		Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж түүнийг	Талбайн хэмжээнд	-	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		дагаж мөрдөх						
2	Гал түймрийн аюул үүсэх	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих	Талбайн хэмжээнд	-	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем, галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
	Нийт							

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалздаг дэлхий нийтийн хандлага бий болж байгаад анхаарч ажиллана. 2026 онд ажилчдын ахуйн бохирыг цэвэршүүлэх төхөөрөмж бүхий стандартад нийцсэн ОО-той болох төлөвлөгөөтэй байна. Энэ ажилтай холбоотой “Экологос” зэрэг байгууллагаас үнийн санал авах, судалгааны ажил хийж эхлээд байна.

Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Ангилсан хог хаягдлаас дахин ашиглах, боловсруулах хог хаягдлыг түүхий эдийн цэгт нийлүүлэх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	-	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Тухай бүр	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагын 2.2.2.а
		Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, яриа таниулга хийх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	-	-	-	1500	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.8, 10.2.16	
		Ажилчдын оо -г эко болгон тохижуулж хөрс бохирдуулахгүй байх стандартад нийцсэн болох , /“Эколог” зэрэг/	Ахуйн гаралтай шингэн хог хаягдал	ш	-	1	Үйл ажиллагааны зардал	2026 онд багтааж		
	Нийт							1500		

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, байгаль орчинд гарсан өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах ёстой. Үүнд тулгуурлан үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаар								
1	- Тоос (TSP) эсвэл PM10, PM2.5 - SO ₂ - NO ₂ - Дуу шуугиан	Талбайн хэмжээнд	Жил бүрийн II, III улиралд	1	200	200		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрс								
2	Физик-химийн үзүүлэлт	Ногоон байгууламжийн н хэсэг	Жилд 1 удаа	1	150	150		MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
3	Хүнд металлын үзүүлэлт	Агуулах орчим, засварын талбай орчим тус тус нэг ш	Жилд 1 удаа	1	250	250		MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ус								
4	Ундны ус	Унд ахуйн ус	Жилд 4 удаа	3	162.5	650		
	Нийт					1050		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2026 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод үйл ажиллагааны зардал	11-р сар	“Сток бласт”ХХК-ийн удирдлагууд
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	Дотоод үйл ажиллагааны зардал	Сар бүр	“Сток бласт”ХХК-ийн удирдлагууд

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хондот багийн иргэдэд БОМТ-нд тусгагдсан ажлыг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллана.

Хүснэгт 12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Харьяа багийн ард иргэд, орон нутгийн захиргааны байгууллагын алба хаагчид	Танилцуулга уулзалт зохион байгуулах	Байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээнэ.	Жил бүрийн III улиралд багтаан хэрэгжүүлнэ.	-	Захиргаа, аж ахуйн албаны дарга, Байгаль орчны асуудал хариуцсан инженер	Харьяа багийн төвийн байранд
	Нийт				-		

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

TDB		ДОТООД ШИЛЖҮҮЛГИЙН МАЯГТ / TRANSFER SLIP						
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК		ОН/YEAR	САР/MONTH	ӨДӨР/DAY	ЦАГ/TIME	ЖУРНАЛ ДУГААР/JOURNAL №	МӨНГӨНИЙ ДҮН (toogoor) /AMOUNT (in figure)	МӨНГӨНИЙ НЭГЖ /CURRENCY
		2025	12	10	16:25:37	947,501,241,994.00	3,500,000.00	MNT
ХААНААС: FROM:	ДАНС ЭЗЭМШИГЧИЙН НЭР /ACCOUNT HOLDER'S NAME: НАРАНТУЯА Оюунбилэг					МӨНГӨНИЙ ДҮН (үсгээр) /AMOUNT (in words) ГУРВАН Сая ТАВАН зуун мянган ТӨГРӨГ		
	ДАНСНЫ ДУГААР /ACCOUNT №: MN550004000456129926					РЕГИСТРИЙН № /PERSONAL ID №: ЧЕ83081761		
ХЭНД: TO:	ХҮЛЭЭН АВАГЧ БАНК /BENEFICIARY'S BANK: Төрийн сан					ТӨЛБӨРИЙН ЗОРИУЛАЛТ /PAYMENT DETAILS СКОТ БЛАСТ ХХК, ЧЕ83081761, 2026 ОН БОМТ БАРЬЦАА		
	ХҮЛЭЭН АВАГЧИЙН ОВОГ, НЭР /BENEFICIARY'S FULL NAME: БО Нөхөн Сэргээх Баталгаа							
	ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨНИЙ НЭГЖ /ACCOUNT №., CURRENCY: MN780090100900013406					ШИМТГЭЛ /FEE: 500.00		
ТЭМДЭГЛЭЛ: NOTE:	ЗАРЛАГА ГАРАХ ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨН ДҮН /SEND ACCOUNT №, AMOUNT: 456129926 3500000					ТАМГА /STAMP, IF ANY		
	ХҮЛЭЭН АВАГЧИЙН БАНК, ОВОГ НЭР, ДАНСНЫ ДУГААР, ДАНСНЫ ВАЛЮТ BENEFICIARY'S BANK, FULL NAME, ACCOUNT NUMBER, CURRENCY: 180090100900013406 Төрийн сан, БОМТ Б					БАТАЛГААТ ГАРЫН ҮСЭГ AUTHORIZED SIGNATURE		
	САНАМЖ /NOTICE: Хариуцагчийн буруугаас шилжүүлэг буцсан тохиолдолд буцсан өдрийн ханшаар буцаах гүйлгээг хийхийг анхаарна уу. Ханшийн зөрүүнээс алдагдал үүсэх тохиолдолд банк хариуцахгүй болно. In case of inward remittance by fault of sender, bank will return the funds to the sender's account exchanging by bank's rate. Sender is responsible for his/her loss.					1st: [Signature] 2nd:		
ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE						ХХБанк Богдхан салбар Хариуцагчийн үйлчилгээний хяналтан		
ХӨРВҮҮЛСЭН ХАНШ: ХҮЛЭЭН АВСАН БАНКНЫ АЖИЛТАН:						Он 2025 Сар 12 Өдөр 10		
ХӨРВӨСӨН ДҮН: ХЯНАСАН:								
Маягт - 004								

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ “СТОК БЛАСТ”ХХК -ИЙН
ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000172982

2012.09.04

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011369037

/ Хувийн хэргийн дугаар /

5631262

/ Регистрийн дугаар /

Сток бласт

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2012.09.03

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

4330

/ код /

Барилгын засвар, үйлчилгээ

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4663

4610

Барилгын материалын худалдаа

Гадаад худалдаа

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

1,000.0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 25-р хороо, хайрхан 2, 90 тоот, Утас1: 88113807, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ захиан олгосон 2018 он 11 сар 15 өдөр



МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 880....

Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл

Үйлдвэрлэлийн зориулалттай
тэсэлгээний ажил явуулах

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр

“СТОК БЛАСТ” ХХК

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг

Улаанбаатар хот, Сонгинохайрхан
дүүрэг, 25 дугаар хороо, Хайрхан,
2-90 тоот

Регистрийн дугаар

5631262

Тусгай зөвшөөрлийн хугацаа

5 /Тав/ жил

Тусгай нөхцөл, шаардлага

Холбогдох хууль, журам, дүрэмд
заасан бүх шаардлагыг хангаж
ажиллах

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2023 оны 06 сарын
27 өдрийн А/23А дугаар тушаалыг үндэслэн олгов.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж. ГАНБААТАР